



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/2021

Чингис хот

Коронавируст (Ковид-19) халдварын үед
эмчилгээний ор дэлгэхтэй холбогдуулан шаардлагатай
тоног төхөөрөмж, эд материалаар хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Онцгой комиссын 2021 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу коронавируст халдварын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Политехник коллежид 100 ор дэлгэж, эмчилгээ үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эд материал худалдан авах санхүүжилтийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосугай.

2. Дээрх зардалд шаардлагатай 14.725.000 (арван дөрвөн сая долоон зуун хорин таван мянга)-н төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгө зарцуулах тооцоог хавсраптаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011616

Политехник коллежид 100 ор дэлгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж,
эд материалын жагсаалт

№	Шаардлагатай зүйлс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Тарианы тэргэнцэр	Ширхэг	3	250,000	750,000
2	Шинжилгээ зөөх сав	Ширхэг	3	200,000	600,000
3	Дуслын хөл	Ширхэг	10	75,000	750,000
4	Жигут	Ширхэг	10	5,000	50,000
5	Хайч	Ширхэг	3	15,000	45,000
6	Зажим	Ширхэг	2	15,000	30,000
7	Кварц	Ширхэг	2	300,000	600,000
8	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	Ширхэг	2	1,800,000	3,600,000
9	Монитор	Ширхэг	2	2,850,000	5,700,000
10	Пульсоксиметр	Ширхэг	2	550,000	1,100,000
11	Даралтын аппарат	Ширхэг	3	450,000	1,350,000
12	Халууны шил /чихээр үзэх/	Ширхэг	2	75,000	150,000
Нийт					14,725,000